



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/254

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын “Сургалтын хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн дагуу жил бүрийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэст, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт, дотоод аудитын хэлтэс (Х.Оюунбилэг)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА



УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалт, 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, газрын “Хөдөлмөрийн дотоод журам” болон төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, эрхийн акт нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.2. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Байгаль орчны салбарын бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг нь байгууллагын хүний нөөцийн мэдлэг, чадвар, дадлага, туршлагаас шууд хамаардаг. Гадаад, дотоод орчны байнгын өөрчлөлт, шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил нь төрийн албан хаагчдаас мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх, шинэ мэдлэг эзэмшихийг шаардаж байна. Иймээс байгууллагын үйл ажиллагааг цаг үеийн хөгжилтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд өргөн хүрээтэй, цогц сургалтын хөтөлбөр боловсруулах зайлшгүй хэрэгцээ тулгарч байгаа юм.

Одоогийн байдлаар Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт нийт 1722 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 600 орчим нь мэргэжлийн бус, 300 гаруй нь бүрэн дунд боловсролтой байна. Энэ нь салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтын хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Тус газар нь 1997 онд батлагдсан “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” хуулийг шинэчлэх, ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, салбарын “Хүн төвт хөгжлийн төлөвлөгөө”-г шинэчлэн сайжруулах чиглэлд үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд техник, технологийн шинэчлэл эрчимтэй өрнөж буйтай зэрэгцэн Дэлхийн цаг уурын байгууллагын чиг хандлагын дагуу тоног төхөөрөмжийг шинэ үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, суперкомпьютерын технологи нэвтрүүлэх болон багаж, тоног төхөөрөмжийн автоматжуулалтын ажлыг зохион байгуулж, үүнээс үүдэн ажилтнуудад шинэ техник, технологийн хэрэглээ, ашиглалт, үйл ажиллагааны онцлогийг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах шаардлага бий болж байна.

Тухайлбал Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д улсын хэмжээнд нэмэлтээр цаг уурын радарын сүлжээ байгуулах ажлыг тусгасан бөгөөд үүнтэй холбоотойгоор цаг уурын радарын хэрэглээний сургалтыг зохион байгуулах, мөн 2027 оны дөрөвдүгээр сард тус газрын харьяа Нислэгийн цаг уурын төвд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын (ICAO)-ын USOAP-CMA бүрэн хэмжээний аудитын шалгалт хийгдэхээр төлөвлөгдсөн тул холбогдох чиглэлийн албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхжуулах зайлшгүй хэрэгцээ бий болж байна.

Иймд дээрх нөхцөл байдал, салбарын шинэчлэл болон технологийн дэвшил, ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдын мэдлэг, ур чадвар, мэргэжлийн

чадавхыг тасралтгүй дээшлүүлэх зорилго бүхий сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь нэн чухал бөгөөд цаг үеийн шаардлага үүсэж байна.

1.3 Хамрах хүрээ:

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчид хамрагдана.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь салбарын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлж, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, байгууллагын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Сургалтын ангилал, чиглэл

3.1 Сургалтыг тухайн албан хаагчийн мэргэжил, мэргэшсэн байдал, ажил байдлын статусаас шалтгаалан доор дурдсанаар ангилна:

- 3.1.1 анхан шатны сургалт;
- 3.1.2 мэргэшүүлэх сургалт;
- 3.1.3 эрх олгох сургалт;
- 3.1.4 удирдлагын чадавх дээшлүүлэх сургалт;
- 3.1.5 тусгай сургалт.

3.2 Анхан шатны сургалт

3.2.1 Төрийн албаны эрх зүйн орчин, байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, дотоод журам, ёс зүй, байгууллагын үнэт зүйлсийн талаар мэдлэг олгоно.

3.2.2 Энэ сургалтын зорилго нь шинээр ажилд орж буй ажилтанд хууль, дүрэм, журам, стандартын талаар мэдлэг өгөхөд оршино.

3.3 Мэргэшүүлэх сургалт

3.3.1 Энэхүү сургалт нь мэдлэг, ур чадвараа ахиулах, сайжруулах, үйл ажиллагаанд нэвтэрч буй сүүлийн үеийн техник технологи, арга зүйг эзэмшихэд чиглэсэн байна.

3.3.2 Мэргэшүүлэх сургалтад дараах чиглэлийн сургалтууд хамаарна:

- а. Техникч, ажиглагчийн мэргэшүүлэх сургалт;
- б. Синоптик, ус судлал, хөдөө аж ахуйн цаг уур, уур амьсгал, мэдээллийн сан, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа, байгаль орчны шинжилгээний лаборатори, цаг уурын радар, аэрологи, багаж хэмжил зүйн инженерүүдийн мэргэшил дээшлүүлэх мэргэшүүлэх сургалт;
- в. Радарын мэдээг урьдчилсан мэдээ гаргахад ашиглах сургалт;
- г. Уур амьсгалын мэдээний боловсруулалт, мэдээллийн сангийн шинэ технологийн сургалт;
- д. Орчны хяналт шинжилгээний технологийн шинэчлэл, нарийн хэмжлийн аналитик багаж тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт;
- е. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалт;
- ё. Байгаль орчны шинжилгээний лабораторийн мэргэжилтнүүдийн давтан сургалт;

ж. Захиргааны чиглэлийн албан хаагчдын мэргэшүүлэх сургалт.

3.3.3 ДЦУБ болон гадаад, дотоодын болон бусад мэргэжлийн байгууллагаас хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах мэргэжилтнүүдийн ажил мэргэжлийн хүрээнд чадавхжуулах мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт, харилцан туршлага солилцох хурал, семинар, онол практик, эрдэм шинжилгээний хурал, мэргэжлийн уулзалт зэргийг мэргэшүүлэх сургалтад тооцно.

3.4 Эрх олгох сургалт

3.4.1 Энэхүү сургалт нь эрх бүхий мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж, мэргэшлийн үнэмлэх олгох, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг сэргээхэд оршино.

а. Нислэгт цаг агаарын урьдчилсан болон бодит ажиглалтын мэдээгээр үйлчилдэг инженер, техникчдэд зориулсан давтан сургалт;

б. Хэмжил зүйн улсын шалгагч, шалгалт тохируулгын ажилтны эрх олгох сургалт;

в. Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцах эрх олгох сургалт;

г. Бусад.

3.5 Удирдлагын чадавх дээшлүүлэх сургалт

3.5.1 Ахлах, дунд шатны болон харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулсан стратеги төлөвлөлт, хүний нөөцийн удирдлага, манлайллын ур чадварыг хөгжүүлэхэд оршино.

3.5.2 Жилд нэгээс доошгүй удаа цахим эсхүл танхимаар зохион байгуулна.

3.6 Тусгай сургалт

3.6.1 Энэхүү сургалт нь төрийн албан хаагчийн ур чадвартай холбоотой Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагатай хэрэгцээг харгалзан зайлшгүй хамрагдах дараах чиглэлийн сургалтууд хамаарна:

а. Хууль эрх зүйн хэрэглээ, төрийн удирдлагын институтийн зорилтот сургалтууд;

б. ХАБЭА сургалт;

в. Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн сургалт;

г. Монгол бичгийн сургалт;

д. Гадаад хэлний сургалт;

е. Бусад.

3.6 Дээрх сургалтуудыг гадаад, дотоодын их дээд сургууль, олон улсын байгууллага, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, ТББ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран урт богино хугацааны дамжаа, сургалтыг зайнаас болон танхимаар зохион байгуулна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Албан хаагчдын боловсролын зэргээ ахиулах хүсэлтийг дэмжин, түүнийг шалгалт өгөх бололцоо нөхцөлөөр ханган, хууль тогтоомжид заасны дагуу олговортой чөлөө олгоно.

4.2 Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамруулна.

4.3 Хүний нөөцийн хөгжлийг дэмжих буцалтгүй тусламжийн хөтөлбөрт хамруулах, мөн өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд төрийн сангийн зээлээр суралцуулах явдлыг дэмжинэ.

4.4 Албан хаагчдыг сургах талаар дотоодын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулна.

4.5 Төрийн Албаны Зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институтийн сургалтын хөтөлбөрт хамруулна.

4.6 Эзэмшсэн мэргэжил болон эрхлэх ажлын чиглэлээр гадаад, дотоодын байгууллагад мэргэжлийг нь дээшлүүлэх, туршлага судлуулах, танилцах сургалтад оролцуулна.

4.7 Магистр, докторын зэрэг олгох судалгааны ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.8 Эзэмшсэн мэргэжлийн дагуу мэргэшүүлэх сургалтад хамруулна.

4.9 Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

4.10 Албан хаагчдын нийтлэг болон салбарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллийг жигд хүргэх зорилгоор шинээр гарсан хууль, дүрэм, журам, тушаал, болон бусад эрх зүйн баримт бичгийг албан хаагчдад хүргэж, таниулна.

4.11 Газрын зөвлөгөөн, хурал, сургалт-семинарыг тодорхой асуудал, сэдвээр тогтмол зохион байгуулна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

5.1 Төрөөс батлан гаргасан, төрийн албан хаагчийн сургалттай холбоотой нэгдсэн бодлого, шийдвэрээр гүйцэтгэнэ.

5.2 Өөрийн байгууллагын боломжийг ашиглана.

5.3 Сургалтын байгууллагатай хамтран ажиллана.

5.4 Гадаад хамтын ажиллагааны боломжийг нэмэгдүүлнэ.

5.5 Хамт олны идэвх санаачилгаар өрнүүлнэ.

5.6 Дотоод, гадаадын төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллана.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа 2025-2029 он.

6.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнана.

6.3 Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар, яам, агентлагийн дарга, харьяа байгууллагын дарга, захирал нар болон албан хаагч, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын тусламжтайгаар хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 7.1.1 Газрын болон харьяа байгууллагын жил бүрийн төсөвт тусгах;
- 7.1.2 Олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт;
- 7.1.3 Төсвийн тухай хуулийн 25.4-д заасны дагуу;
- 7.1.4 Гадаад, дотоодын төсөл хөтөлбөр;
- 7.1.5 Байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлого;
- 7.1.6 Бусад хуулиар хориглоогүй эх үүсвэр.

Найм. Хөтөлбөрийн үр дүн

8.1 Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хувь хүн буюу албан хаагчийн мэдлэг ур чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг ур чадвар, туршлага болгон хэрэгжүүлснээр төрийн албыг мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр бүрдүүлж, иргэд, төр засагт үзүүлэх үйлчилгээ чанартай, бодлого шийдвэр оновчтой болно.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт

9.1 Хөтөлбөрийн хэрэгжилтэд Захиргааны хэлтэс хяналт тавина.

9.2 Хэрэгжилтэд үе шаттай хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж, сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр эргэх холбоо бий болгоно.

9.3 Сургалттай холбоотой асуудлыг төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт”-д тодорхой тусган, биелэлт, үр дүнг дүгнэнэ.

----oO----